|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.5 | Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдыг ашиглалтын шаардлага хангасан компьютерээр хангана | - | Ашиглалтын шаардлага хангасан компьютертэй цэцэрлэгийн багшийн эзлэх жин Ашиглалтын шаардлага хангасан компьютертэй сургуулийн багшийн эзлэх жин Ашиглалтын шаардлага хангасан компьютертэй МБС, ПК-ын багшийн эзлэх жин Ашиглалтын шаардлага хангасан компьютертэй насан туршийн суралцахуйн төвийн багшийн эзлэх жин | 10 / 35 / 44.4 / 2 | 10 / 35 / 44.4 / 2 | 50 / 65 / 55 / 30 | БЯ-ны ТНБД-ын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/12 дугаар тушаалаар боловсролын байгууллагын сургалт, судалгаа, өдөр тутмын хэрэглээнд нийцсэн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт боловсруулах, зах зээлийн үнийн судалгаа хийх, худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, 2025 онд худалдан авах компьютер, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан. Уг техникийн тодорхойлолтод үндэслэн худалдан авах ажиллагааны газраас Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол/ БЯ/20250102020, Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Увс/ БЯ/20250102023, Боловсролын салбарын сургалтын хэрэгцээнд зөөврийн компьютер худалдан авах БЯ/20250102019 тус тус тендерийг нээлттэй зарлаж, нийт 840 ширхэг Intel i5 төрлийн зөөврийн компьютер худалдан авахаар төлөвлөсөн. Тендерийн баримт бичиг болон техникийн шаардлагад нийцсэн байгууллагуудыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан нийлүүлэлтийн ажлыг эхлүүлээд байна. Тус ажлын хэрэгжилт нь боловсролын салбарын дижитал шилжилтийг дэмжих, багш ажилтнуудын ажлын гүйцэтгэл, сургалтын чанарыг сайжруулах, мэдээллийн технологийн тэгш хүртээмжийг бий болгох, боловсролын байгууллагын техник технологийн орчныг сайжруулах | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зорилготой бөгөөд цаашдын бодлогын хэрэгжилт, сургалтын чанарт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм. Боловсролын дэлхийн түншлэл ОУ-н байгууллагын "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд зорилтот ЕБС-д тоног төөхөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 350 ширхэг Chromebook зөөврийн компьютер худалдан авч сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд суралцаж буй ЕБС, их, дээд сургууль, НТБТ-д нийлүүлсэн. Хавсралт: 5 файл | | |
| 1.5.6 | Боловсролын сургалтын байгууллагад нэгдсэн стандарт, архитектур бүхий удирдлага, мэдээллийн системийг нэвтрүүлж, мэдээлэл солилцоог сайжруулна. | - | Систем нэвтрүүлсэн цэцэрлэгийн тоо Систем нэвтрүүлсэн ерөнхий боловсролын сургуулийн тоо Систем нэвтрүүлсэн МБС, ПК тоо | 250 / 185 / 0 | 250 / 185 / 0 | 500 / 300 / 10 | Боловсролын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.7 дах хэсгийг үндэслэн Боловсролын сайдын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/260 дугаар тушаалаар “Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам” батлагдсан мөн Боловсролын сайдын 2024 оны “Шаардлага шинэчлэн батлах тухай” А/261 дүгээр тушаалаар боловсролын сургалтын байгууллагад боловсрол, сургалтын зориулалтаар ашиглах мэдээллийг системд тавих ерөнхий болон тусгай шаардлага, санхүүжүүлэх эх үүсвэрийн мэдээлэл тус тус батлагдсан. Эдгээр журам, шаардлага батлагдсанаар бүх түвшний боловсрол сургалтын байгууллага нь өөрийн байгууллагын үйл ажиллагаанд хувь хүн, хуулийн этгээдийн боловсруулсан систем, программ хангамжаас Боловсролын ерөнхий хуулийн 34.1, 34.2 дугаарт заасан удирдах зөвлөл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон зөвлөлийн шийдвэрийг үндэслэн сонгон ашиглах, ашиглалтыг зардлыг хувьсах зардал болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх зохицуулалттай болсон. Мөн ТНБД-ын 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/02 дугаар тушаалаар БСМС-ийн, "Төлөвлөгөө батлах тухай" А/130 дугаар тушаалаар ДБУМС-ийн мэдээлэл солилцох сервис хөгжүүлэлтийн төлөвлөлтийг тус тус баталж, БМТТ-д хөгжүүлж, нэвтрүүлэх үүрэг өгөгдсөн. Дээрх журмын дагуу Боловсролын яам LMS/SMS, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний, номын сангийн, цахим гэрээний, дээд боловсролын байгууллагын удирдлагын, шалгалтын зэрэг нийт 213 байгууллагатай "Мэдээлэл солилцох гэрээ" байгуулаад байна. Хагас жилийн байдлаар 849 ЕБС, 454 цэцэрлэг сургалтын үйл ажиллагаандаа нэгдсэн стандарт, архитектур бүхий удирдлага, мэдээллийн системийг нэвтрүүлж, БСМС-тэй мэдээлэл солилцож байна. Дээрх батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ЕБС-ын дэвшилт, төгсөлтийн үйл ажиллагааг 100 хувь хувийн хэвшлийн хөгжүүлсэн системээс зохион байгуулахтай холбоотойгоор хөгжүүлэгч компаниудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг ТНБД-ын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/13 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.6. | Иргэдэд | - | Систем | 0% | 25% | | Бүлэг дүүргэлт, багшийн хүрэлцээгүй | 100% | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | насан туршдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлж, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, хүн бүрд орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, боловсрол эзэмших тэгш хүртээмжтэй сургалтын контент, мэдээллийн системийг нэвтрүүлж, ур чадвар, чадамжийг дэмжсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, гэрчилгээ олгох, микро кредитийн сургалтыг холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлнэ. Хилийн чанадад | | хөгжүүлэлтийн хувь | | | байдлаас шалтгаалан хөдөөгийн сургуулийн ахлах ангийн суралцагчдын дунд үүсдэг бэрхшээлийг арилгах, тэдэнд сонгон судлах хичээлээ судлах тэгш боломж олгох, хилийн чанадад байгаа монгол хүүхдэд монгол хэл, монголын түүх, соёл, үндэсний өв уламжлал, зан заншлаас сургах зорилготой ахлах ангийн сонгон судлах хичээлийн цахим сургуулийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 2024-2025 оны хичээлийн жилд бүлэг бүрдээгүй 432 /нийслэл-114, аймгийн төв-102, сум-207, баг-8, Солонгос улс дахь-1/ сургуулийн 10-р ангийн 7,074, 11-р ангийн 5,531 сурагч, 12-р ангийн 4,848 сурагч, нийт 17,453 суралцагч суралцаж байна. Цахим сургалт зохион байгуулах чадавхтай багш бэлтгэх зорилгоор гурван удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, нийт 891 багш хамрагдсан. Хичээлийн жилийн явцад багш нарын цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор танхим болон цахим хэлбэр хосолсон сургалтыг зохион байгуулж, нийт 4 аймгийн 655 багшийг хамруулсан. Мөн насан туршийн суралцахуйн төвүүдийн багш нарт боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэх чадавх эзэмшүүлэх зорилгоор 21 аймаг, 9 дүүргийн нийт 571 багшид зориулсан гурван сарын цахим сургалтыг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд үндэслэн цахим сургууль байгуулах 4 хувилбар боловсруулж сайд, удирдлагуудад танилцуулсан. Боловсролын ерөнхий хуулийн | | % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | амьдарч буй гэр бүл, хүүхдүүдэд зориулсан монгол хэл, соёлд суралцах хөтөлбөр хэрэгжүүлж, цахим сургалтын агуулгыг нэмэгдүүлнэ. | | | | | | холбогдох заалт болон ЗГҮАХ-ийн 4.4.1.5.-д “Хилийн чанадад амьдарч байгаа гэр бүл, хүүхдүүдэд зориулсан монгол хэл, соёлд суралцах хөтөлбөр хэрэгжүүлж, цахим сургалтын агуулгыг нэмэгдүүлнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлэх зорилгоор 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн Монгол хэл, соёлын нэгдмэл хөтөлбөрийг боловсруулан, хилийн чандад байгаа суралцагчдад зориулсан цахим сургалт зохион байгуулахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнтэй холбоотойгоор Гадаад харилцааны сайд руу "Хамтран ажиллах тухай" 1/1691 тоот албан бичиг хүргүүлэн дээрх хөтөлбөрт хамрагдах иргэдийг бүртгэх ажилд хамтран ажиллаж байна. | | |
| 1.6.1 | Иргэдийн насан туршдаа суралцахуйн удирдлага мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ. | - | Систем хөгжүүлэлтийн хувь | 0 | 5 | 25 | Боловсролын удирдлага мэдээллийн систем (ESIS)-д насан туршийн суралцахуйн чиглэлээр 5 төрлийн 15 маягтыг боловсруулсан. Холбогдох газар, хэлтсийн мэргэжилтнээс санал авч З-БДБ-НТБ-1, З-БДБ-НТБ-1.1, З-БДБ-НТБ-2, З-БДБ-НТБ-2.1 маягтыг сайжруулж (ESIS)-ээс тайланг татаж авах боломжтой болсон. Мөн аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн хувь хүний хөгжил, амьдрах ухааны сургалтад хамрагдаж буй иргэдийг бүртгэлжүүлэх зорилгоор “гэр бүлийн боловсролын чиглэлээр зохион байгуулсан сургалт”, “Иргэдэд чиглэсэн сургалт, үйл ажиллагаа”, “Ерөнхий боловсролын агуулгыг бие даан эзэмшсэн иргэний бүртгэл”-ийн маягтыг боловсруулсан. 2024-2025 оны хичээлийн жилд явцад багш нарын | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахим ур чадварыг нэмэгдүүлэх, мэдээлэл технологид суурилсан сургалт зохион байгуулах арга зүйг сайжруулах зорилгоор танхим болон цахим хэлбэр хосолсон сургалтыг зохион байгуулж, нийт 4 аймгийн 655 багшийг хамруулсан. Мөн насан туршийн суралцахуйн төвүүдийн багш нарт боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэх чадавх эзэмшүүлэх зорилгоор 21 аймаг, 9 дүүргийн нийт 571 багшид зориулсан гурван сарын цахим сургалтыг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. | | |
| 1.7. | Сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт боловсруулж, мөрдөнө. | - | Стандартын боловсруулалт, хэрэгжилтийн хувь | 0% | 5% | | Нийгмийн цахим сүлжээнд 16 хүртлэх насны хүүхдийн оролцоог зохицуулах ажлын хүрээнд Австралийн Холбооны Засгийн газар 2024 оны 11-р сарын 29-нд "Онлайн аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах (Нийгмийн сүлжээний насны доод хязгаар) тухай" хуулийг орчуулан ажлын хэсгээр хэлэлцүүлсэн. Энэхүү хууль нь нийгмийн сүлжээний платформд 16-аас доош насны хэрэглэгчдийг бүртгэхээс сэргийлэх, нийгмийн сүлжээний платформын үйлчилгээ үзүүлэгч нарт үүрэг хүлээлгэж, хүүхдийг цахим орчны хортой нөлөөллөөс хамгаалах зорилготой юм. ОНЦМА төслийн оролоцогч нараар дамжуулан Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар судалгааг 7-18 настай хүүхэдтэй 810 эцэг эх% асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 13-18 настай 750 орчих хүүхдээс авч, судалгааны танилцуулгыг бэлтгэж ажлын хэсэгт | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлсэн. Судалгаанд оролцогч 7-18 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дийлэнх (70.6%) нь мэдээллээ Фэйсбүүкээр авч, өдөрт 1-4 цаг цахим орчинд өнгөрүүлдэг. Тэдний хүүхдүүд интернэтэд голчлон ухаалаг гар утсаар хандаж (77.2%), өдөрт 1-2 цаг (26.4%) зарцуулдаг бөгөөд Youtube (44.9%) болон TikTok (25.9%) зэрэг сошиал медиаг идэвхтэй ашигладаг. Эцэг эхчүүд хүүхдийн цахим хэрэглээг хянах нь өөрсдийн үүрэг гэдэгтэй санал нэгтэй (89%) боловч, интернэт тоглоом, веб сайтуудын насны хязгаарлалтыг хангалтгүй (71.1%) гэж үздэг. Цахим орчны эрсдэлээс хамгийн их болгоомжилж буй зүйл нь танихгүй хүнтэй харилцах (25.4%), хуурамч мэдээлэлд итгэх (20.7%), цахим халдлага (42.1%) болон сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх (23.6%) явдал байна. Харамсалтай нь, оролцогчдын 52.2% нь өсвөр насны хүүхэд цахим халдлагын улмаас амиа егүүтгэх талаар ярьж байхыг сонссон байна. Стандарт нь төлөвлөгөө ёсоор эхний хагас жилд ажил хийгдэхгүй бөгөөд сүүлийн хагас жилд "Хүүхэд, залуучуудыг сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт" боловсруулах ажлын хэсэг байгуулж, Стандарт хэмжил зүйн газрын 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. | | |
| 1.7.1 | Хүүхэд, залуучуудыг сургалтын байгууллагын | - | Стандартын боловсруулалт, хэрэгжилтийн | 0 % | 0 % | 5 % | Нийгмийн цахим сүлжээнд 16 хүртлэх насны хүүхдийн оролцоог зохицуулах ажлын хүрээнд Австралийн Холбооны Засгийн газар 2024 оны 11-р сарын 29- | 90% | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орчинд цахим эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт боловсруулж мөрдөнө. | | хувь | | | | нд "Онлайн аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах (Нийгмийн сүлжээний насны доод хязгаар) тухай" хуулийг орчуулан ажлын хэсгээр хэлэлцүүлсэн. Энэхүү хууль нь нийгмийн сүлжээний платформд 16-аас доош насны хэрэглэгчдийг бүртгэхээс сэргийлэх, нийгмийн сүлжээний платформын үйлчилгээ үзүүлэгч нарт үүрэг хүлээлгэж, хүүхдийг цахим орчны хортой нөлөөллөөс хамгаалах зорилготой юм. ОНЦМА төслийн оролоцогч нараар дамжуулан Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар судалгааг 7-18 настай хүүхэдтэй 810 эцэг эх% асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 13-18 настай 750 орчих хүүхдээс авч, судалгааны танилцуулгыг бэлтгэж ажлын хэсэгт хүргүүлсэн. Судалгаанд оролцогч 7-18 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дийлэнх (70.6%) нь мэдээллээ Фэйсбүүкээр авч, өдөрт 1-4 цаг цахим орчинд өнгөрүүлдэг. Тэдний хүүхдүүд интернэтэд голчлон ухаалаг гар утсаар хандаж (77.2%), өдөрт 1-2 цаг (26.4%) зарцуулдаг бөгөөд Youtube (44.9%) болон TikTok (25.9%) зэрэг сошиал медиаг идэвхтэй ашигладаг. Эцэг эхчүүд хүүхдийн цахим хэрэглээг хянах нь өөрсдийн үүрэг гэдэгтэй санал нэгтэй (89%) боловч, интернэт тоглоом, веб сайтуудын насны хязгаарлалтыг хангалтгүй (71.1%) гэж үздэг. Цахим орчны эрсдэлээс хамгийн их болгоомжилж буй зүйл нь танихгүй хүнтэй харилцах (25.4%), хуурамч мэдээлэлд итгэх (20.7%), цахим халдлага (42.1%) болон сэтгэцийн эрүүл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэндэд сөргөөр нөлөөлөх (23.6%) явдал байна. Харамсалтай нь, оролцогчдын 52.2% нь өсвөр насны хүүхэд цахим халдлагын улмаас амиа егүүтгэх талаар ярьж байхыг сонссон байна. Стандарт нь төлөвлөгөө ёсоор эхний хагас жилд ажил хийгдэхгүй бөгөөд сүүлийн хагас жилд "Хүүхэд, залуучуудыг сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт" боловсруулах ажлын хэсэг байгуулж, Стандарт хэмжил зүйн газрын 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. | | |
| 1.8. | Сургалтын байгууллагын интернэтийн дэд бүтцийг сайжруулах, хүүхэд бүрийг компьютерээр хангах санхүүгийн түрээсийн системийг нэвтрүүлнэ. | - | Интернэт сүлжээнд холбогдсон боловсрол, сургалтын байгууллагын анги танхим, дотуур байрны хувь / Нэг компьютерт ногдох ерөнхий боловсролын сургуулийн 3-12 дугаар ангийн суралцагчийн тоо | 30% / 10.9 | 50% / 10 | | Төрийн өмчийн ЕБС-ийн сургалтын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, интернэт урсгалын хурд, хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор орон нутгийн тоон суваг, байр талбайн түрээс, сүлжээний дэд бүтцийн ашиглалт, аюулгүй байдлыг хангах, нийслэлийн зарим сургууль, харьяа байгууллагын интернэтийн үйлчилгээнд шаардагдах зардлыг Боловсролын сайдын 2025 оны “Зардал батлах тухай” А/39 дүгээр тушаалын батлагдсан. Үүнтэй холбоотойгоор Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/91 тоот албан бичгээр Аймаг, нийслэлийн боловсролын газруудад ЕБС-ийн интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгох, гэрээ байгуулах, хамтран ажиллах талаар холбогдох чиглэл хүргүүлсэн. Тус чиглэлийн дагуу ЕБС интернэт үйлчилгээ үзүүлэх оператор компанийг өөрөө сонгож үйлчилгээ авч, төлбөрийг дээрх зардлаас санхүүжүүлж эхэлсэн. Тус үйл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааг зохион байлснаар ЕБС-н интернэтийн дундаж хурд оны эхэнд 16 mbps байсан бол хагас жилийн байдлаар 48.5 mbps болж өссөн байна. Сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын бүрэлдэхүүн болох нөхөн хангалтын зардлаар 2024 онд сургуулийн дотоод сүлжээг шинэчлэх, цахим анги бий болгох арга хэмжээг санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр худалдан авах арга хэмжээг зохион байгуулсан. Утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх төсөл арга хэмжээг 24 сарын хугацаанд, цахим танхим байгуулах төсөл арга хэмжээг 48 сарын хугацаанд төлбөрийг хуваан төлөх нөхцөлтэй ерөнхий гэрээний журмаар зохион байгуулж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар байдлаар 705 сургуулиас утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх ажил дээр 543 сургууль, цахим танхим байгуулах ажил дээр 298 захиалга өгч гэрээ байгуулж, суурилуулалтын ажлыг гүйцэтгээд байна. | | |
| 1.8.1 | Боловсролын нэгдсэн сүлжээний төв, зангилаа төвүүд болон дэд бүтцийн өргөтгөл хийж ачааллыг нэмэгдүүлж, боловсролын сургалтын бүх | 4,5 тэрбум төгрөг | Санах ойн багтаамжийн хэмжээ | 18ТВ | 18ТВ | 24ТВ | Төрийн өмчийн ЕБС-ийн сургалтын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, интернэт урсгалын хурд, хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор орон нутгийн тоон суваг, байр талбайн түрээс, сүлжээний дэд бүтцийн ашиглалт, аюулгүй байдлыг хангах, нийслэлийн зарим сургууль, харьяа байгууллагын интернэтийн үйлчилгээнд шаардагдах зардлыг Боловсролын сайдын 2025 оны “Зардал батлах тухай” А/39 дүгээр тушаалын батлагдсан. Үүнтэй холбоотойгоор Боловсролын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно. | | | | | | сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/91 тоот албан бичгээр Аймаг, нийслэлийн боловсролын газруудад ЕБС-ийн интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгох, гэрээ байгуулах, хамтран ажиллах талаар холбогдох чиглэл хүргүүлсэн. Тус чиглэлийн дагуу ЕБС интернэт үйлчилгээ үзүүлэх оператор компанийг өөрөө сонгож үйлчилгээ авч, төлбөрийг дээрх зардлаас санхүүжүүлж эхэлсэн. Тус үйл ажиллагааг зохион байлснаар ЕБС-н интернэтийн дундаж хурд оны эхэнд 16 mbps байсан бол хагас жилийн байдлаар 48.5 mbps болж өссөн байна. Боловсролын сайдын хүсэлт хүргүүлэх тухай 1/553 тоот албан бичиг хүргүүлсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын сонгуулийн ерөнхий хороонд 2024 оны сонгуулийн үйл ажиллагаанд ашигласан нам орбитын хиймэл дагуулын интернэт үйлчилгээний 25 ширхэг төхөөрөмж (Starlink)-ийг алслагдсан бүс нутгийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд ашиглуулах зорилгоор хүлээлгэн өгсөн ба Боловсролын сайдын 2025 оны "Хиймэл дагуулын төхөөрөмж (Starlink) хуваарилах тухай" А/121 дүгээр тушаалаар хуваарийг батлан алслагдсан сум, багийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй 25 ЕБС-д хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар "Боловсролын дата төвийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлж, найдвартай ажиллагааг хангах, техник технологийн орчныг бүрдүүлэх" ажилд 4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд БЯ/20250102024 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаартай худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, Саммит компьютер технологи ХХК шалгарч, гүйцэтгэгчтэй УТ2501513951-XIV.1.3.1.17 тоот гэрээг байгуулсан.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.8.2 | "Нэг суралцагчид нэг компьютер" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - | Нэг компьютерт ногдох ерөнхий боловсролын сургуулийн 3-12 дугаар ангийн суралцагчийн тоо Нэг компьютерт ногдох мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн суралцагчийн тоо | 10.9 / 8.4 | 10.9 / 8.4 | 10 / 7 | Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/12 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, боловсролын сургалтын байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтын техникийн тодорхойлолт боловсруулах, зах зээлийн үнийн судалгаа хийх, худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэв. Уг ажлын хүрээнд боловсролын байгууллагад ашиглах зөөврийн болон суурин компьютер, таблет, ухаалаг самбар, телевизор, мөн зөөврийн төхөөрөмж (зөөврийн компьютер, таблет)-ийг цэнэглэх, хадгалах, зөөвөрлөх зориулалт бүхий ухаалаг төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Эдгээр техникийн тодорхойлолтод үндэслэн Төрийн худалдан авах ажиллагааны газраас 10 нээлттэй тендер, 2 ерөнхий гэрээний аргаар нийт 12 тендер зарлаж, одоогийн байдлаар 9 тендерийн шалгаруулалт амжилттай хийгдээд байна. Тендерийн үр дүнд боловсролын сургалтын зориулалтаар нийт 60 суурин компьютер, 790 зөөврийн компьютер, | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 320 хромбүүк, 132 ухаалаг самбар, 200 таблет худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд энэхүү худалдан авалт нь “Нэг сурагч – нэг төхөөрөмж” зорилтыг хангах, дижитал хичээл болон цахим орчны хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын байгууллагын техник, технологийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдэж байна. Мөн Боловсролын дэлхийн түншлэл ОУ-н байгууллагын "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд зорилтот ЕБС-д тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд 350 ширхэг Chromebook зөөврийн компьютер худалдан авч сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд суралцаж буй ЕБС, их, дээд сургууль, НТБТ-д нийлүүлсэн.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.9. | Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн | - | - | - | - | | 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэх, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журам”-ын 4.1-т заасны дагуу тухай бүрд нээлттэй мэдээллийн нэгдсэн “shilen.gov.mn” системд байршуулах ажлыг эрчимжүүлэх талаар харьяа 7 байгууллагад албан бичиг хүргүүлж, холбогдох админаар ажиллах албан хаагчийн мэдээллийг шинэчилсэн. 2.Төрийн нэгдсэн мэдээллийн opendata.gov.mn системд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ил тод байдлыг ханган ажиллана. | | | | | | тухай бүр байршуулах элсэлтийн ерөнхий шалгалтын 10 хичээлийн 4 хувилбар бүхий 40 мэдээллийг оруулсан. 3.Монгол улсын Засгийн газрын 2024 оны “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 96 дугаар тогтоолоор шинэчлэгдсэн батлагдсан жагсаалтын дагуу 4 өгөгдлийг байршуулахад Боловсролын ерөнхий газрын админыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж, албаны тоон гарын үсэгтэй болгоход дэмжлэг үзүүлэн ажилласан | | |
| 1.9.1 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | - | Мэдээллийн тоо | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. | 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэх, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоон, үнэлгээ хийх журам”-ын 4.1-т заасны дагуу тухай бүрд нээлттэй мэдээллийн нэгдсэн “shilen.gov.mn” системд байршуулах ажлыг эрчимжүүлэх талаар харьяа 7 байгууллагад албан бичиг хүргүүлж, холбогдох админаар ажиллах албан хаагчийн мэдээллийг шинэчилсэн. 2.Төрийн нэгдсэн мэдээллийн opendata.gov.mn системд тухай бүр байршуулах элсэлтийн ерөнхий шалгалтын 10 хичээлийн 4 хувилбар бүхий 40 мэдээллийг оруулсан. 3.Монгол улсын Засгийн газрын 2024 оны “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 96 дугаар тогтоолоор шинэчлэгдсэн батлагдсан жагсаалтын дагуу 4 өгөгдлийг байршуулахад | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боловсролын ерөнхий газрын админыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаж, албаны тоон гарын үсэгтэй болгоход дэмжлэг үзүүлэн ажилласан<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.10. | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | - | - | - | - | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээ, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд тайлагнаж, арга хэмжээг нэгжийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | 100 % |
| 1.10. 1 | Урт болон богино хугацааны бодлогын баримт | - | Биелэлтийн хувь | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | 100 | 100 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах | | | | | | арга хэмжээ, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд тайлагнаж, арга хэмжээг нэгжийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |

*Үнэлсэн:* .........................

.......................................... ......................... /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

.......................................... ......................... /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*